



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 10


Улаанбаатар хот

Г Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хэсэгчлэн түр зогсоох тухай Г

Улсын онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн XIX хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсад КОВИД-19-ын халдвартын бүртгэгдсэн тохиолдлын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан халдвартын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн орох, гарах чиглэлийн хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгсэл, суудлын галт тэрэгний хөдөлгөөнийг 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 21:00 цагаас 2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 06:00 цаг хүртэл түр зогсоож, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал С.Баатаржав, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮҮВШИН